

ГАЛТ ТЭРЭГНИЙ БОЛОН СЭЛГЭЭНИЙ ХӨДӨЛГӨӨНТЭЙ ШУУД ХОЛБООТОЙ АЖИЛТНЫ САХИЛГЫН ТУСГАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Төмөр замын тээврийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ажилтны хөдөлмөрийн үүрэг, сахилга, шагнал урамшуулал, сахилгын шийтгэл болон ажил, амралтын хуваарийг тогтооход оршино.
- 1.2. Энэхүү журмыг төмөр замын байгууллага болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн угсрах, засварлах тусгай зөвшөөрөлтэй эдгээд, мөн засвар үйлчилгээ эрхлэх гэрчилгээтэй хуулийн этгээдийн галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан /цаашид “Төмөр замын ажилтан” гэх/ дагаж мөрдөнө.
- 1.3. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтан ажиллах байнгын ажлын байранд зөвхөн хөдөлмөрийн гэрээ байгуулна.
- 1.4. Төмөр замын ажилтны хөдөлмөрийн сахилга нь хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, тушаал, заавар, удирдах албан тушаалтны өгсөн үүрэг даалгаварыг мөрдөх, биелүүлэх ба өөрийн хөдөлмөрийн үндсэн үүргээ гүйцэтгэснээр хангагдана.
- 1.5. Төмөр замын ажилтан нь төмөр замын тээврийн аюулгүй байдал, тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний технологийг сахин биелүүлэх, зорчигчийг эрүүл аюулгүй зорчуулах, ачаа, ачаан тээшийг аюулгүй тээвэрлэх, ослоос урьдчилан сэргийлэх, ослын үр дагаврыг арилгах, иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө болон байгаль орчин, хүний ам нас, эрүүл мэндийг хамгаалах үндсэн үүрэгтэй.

Хоёр. Төмөр замын ажилтны үүрэг

- 2.1. Төмөр замын ажилтан нь хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээ, тушаал, зааврыг дагаж мөрдөн, удирдах албан тушаалтны албан үүргийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, дор дурдсан хөдөлмөрийн үндсэн үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 2.1.1. Олон Улсын гэрээ, Монгол Улсын хууль тогтоомж, Төмөр замын тээврийн тухай хууль, төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон галын аюулгүй байдлын стандарт, зааврыг судалж, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх;
 - 2.1.2. Төмөр замын тээврийн болон галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, галын аюулгүй байдлыг хангах, зорчигчийг эрүүл аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, зорчигч, ачаа, ачаан тээшийг цаг тухайд тээвэрлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх, галт тэрэгний зурмагийг мөрдөх;
 - 2.1.3. Төмөр замын техник ашиглалтын дүрэм, Дохиоллын журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам бусад холбогдох дүрэм журмын мэдлэгээр шалгалт өгч, тэнцсэн, техникийн сургалт, аттестатчилалд хамрагдсан, дадлага туршлагатай байх, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлдэг байх,

- 2.1.4. Байгууллагын удирдлага, шууд харьяалах албан тушаалтан, ажлын ахлагч нарын албан үүргийн хүрээнд өгсөн тушаал, заавар, зааварчилгыг цаг тухайд нь, бүрэн гүйцэд биелүүлэх;
- 2.1.5. Хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй нөхцөл бүрдсэн, байгууламж, төхөөрөмжид гэмтэл, хэвийн бус ажиллагаа болон түүнд хүргэж болзошгүй нөхцөл байдлын талаар тухай бүрд нь дээд шатны удирдах албан тушаалтан, холбогдох ажилтанд шуурхай мэдэгдэх;
- 2.1.6. Эрхэлсэн ажилтай нь холбогдуулан олгосон ажлын тусгай болон дүрэмт хувцас, бие хамгаалах болон дохионы хэрэгслийг тогтоосон журамд зааснаар зориулалтын дагуу хэрэглэх;
- 2.1.7. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, хөдөлгөөний нэгдсэн болон суурь бүтэц дэх зурмагийг чанд биелүүлж ажиллах;
- 2.1.8. Мэргэжлийн ба зохих зэрэглэлийн үнэмлэхтэй, техник ашиглалт, аюулгүй ажиллагааны арга барил эзэмшсэн байх;
- 2.1.9. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнийг оновчтой, шуурхай зохион байгуулж, төмөр замын тээврийн аюулгүй, тасралтгүй, хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон тушаал, захирамжийг заавал биелүүлэх;
- 2.1.10. Зорчигчийн ая тухтай зорчих нөхцөлийг хангах, ачаа, тээш, ачаан тээшний бүрэн бүтэн байдал, төмөр замын байгууллагын эд хөрөнгө, сэлбэг материалыг арчлан хамгаалах;
- 2.1.11. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа албан ярианы дэглэмийг баримталж ажиллах;
- 2.1.12. Харилцагч байгууллага, иргэдийг тээвэрлэлт, ажил, үйлчилгээтэй холбогдолтой үнэн зөв мэдээллээр хангаж, хөнгөн шуурхай, соёлтой боловсон үйлчилж, ажил үйлчилгээний болон галт тэрэгний цагийн хуваарийг чанд баримтлах;
- 2.1.13. Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн биелүүлж, тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт орсон байх;
- 2.1.14. Хариуцсан объектод байнга үзлэг, үйлчилгээ хийж, илэрсэн эвдрэл, гэмтэл, хэвийн бус ажиллагаа болон түүнд хүргэж болзошгүй нөхцөл байдлын талаар тухай бүрд нь дээд шатны удирдах албан тушаалтан, холбогдох ажилтанд шуурхай мэдэгдэх;
- 2.1.15. Авилга, хээл хахууль, шан харамж авах, өгөх, өгөхийг шаардах, танил тал харах, үйлчлүүлэгчид тэгш бус хандаж, аль нэгэнд нь давуу эрх олгох зэргээр төмөр замын байгууллагын нэр хүндэд харшлах үйлдэл гаргахгүй байх;
- 2.1.16. Хүний эрүүл мэнд, амь насанд аюул учирч болзошгүй нөхцөл бүрдсэн, ачаа, тээш, ачаан тээшинд эвдрэл, гэмтэл гарсан, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад саад тохиолдвол хөдөлгөөнийг нэн даруй зогсоох арга хэмжээ авах, байгууламж, төхөөрөмжид гэмтэл илрүүлбэл тухайн осолтой газрыг хааж хамгаалах, засварлах арга хэмжээг яаралтай авч байх;
- 2.1.17. Байгалийн гамшиг, сүйрэл, осол, гологдлын хор уршгийг арилгах ажилд оролцуулахаар дуудсан тохиолдолд анхны дуудлагаар ажлын байранд хүрэлцэн ирэх, зааварчилгын дагуу ажил гүйцэтгэх;
- 2.2. Төмөр замын ажилтныг шууд харьяалах албан тушаалтан, ажлын ахлагч ажилтан нь дор дурдсан үүрэгтэй. Үүнд:

- 2.2.1. Тушаал, шийдвэр, заавар, үүрэг даалгаврыг тодорхой, ойлгомжтой өгөх, гүйцэтгэлийг бүрэн хангуулах, хянах, шалгах, шуурхай холбогдох арга хэмжээг авах, тайлагнах, мэдээлэх;
- 2.2.2. Хэрэв хууль бус, төмөр замын тээврийн аюулгүй байдалд сөрөг үйл ажиллагаа илэрвэл цаг алдалгүй таслан зогсоож, байгууллага эсвэл нэгжийн удирдлага, албан тушаалтанд мэдэгдэж, өөрийн эрх, үүргийн хүрээнд холбогдох арга хэмжээ авах;
- 2.3. Ээлж хүлээн авах, ажил хэвийн гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй үед ээлж хүлээлцэх шийдвэр гаргасан удирдах ажилтан түүнээс үүдэн гарах хариуцлагыг хүлээнэ.
- 2.4. Ажлын байр эзэнгүй орхих, ажлын байранд унтах, бусадтай ажилтай холбогдолгүй яриа өрнүүлэх зэргээр ажил цалгардуулах, зөрчил дутагдлыг нуун дарагдуулах, эвлэрэн хаацайлахыг хориглоно.
- 2.5. Ажлын байранд ажил гүйцэтгэхэд саад болох техник хэрэгсэл, эд материал /зөвшөөрөгдсөнөөс бусад/ хадгалах, гадны хүн байлгахыг хориглоно.

Гурав. Шагнал урамшуулал

- 3.1. Хүний эрүүл мэнд, амь нас, ачаа, тээш, ачаан тээш, эд хөрөнгийг авран хамгаалсан, сүйрэл, осол, гологдлоос урьдчилан сэргийлсэн, ажлын бүтээмж, чанарыг сайжруулахад шинэ санал санаачилга гаргаж үр дүн үзүүлсэн, хөдөлмөрийн тодорхой амжилт гаргасан төмөр замын байгууллагын ажилтанд шагнал урамшуулал олгож болно.
- 3.2. Энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасан төмөр замын ажилтанд дараах шагнал урамшуулал олгоно. Үүнд:
 - 3.2.1. Төрийн шагнал;
 - 3.2.2. Засгийн газрын шагнал;
 - 3.2.3. Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шагнал;
 - 3.2.4. Төмөр замын байгууллагын шагнал;
 - 3.2.5. Бусад байгууллагын шагнал, урамшуулал.
- 3.3. Төр, засгийн шагналд нэр дэвшүүлж байгаа ажилтныг төмөр замын байгууллагын дарга хууль тогтоомжийн дагуу холбогдох байгууллагад тодорхойлно.
- 3.4. Төмөр замын байгууллага нь шагнал, урамшууллын журамтай байж байгууллагын жуух, тэмдэг, хүндэт дэвтэрт бичих, самбарт гаргах, болон бусад хэлбэрийн шагнал, урамшуулал олгож болно.
- 3.5. Төмөр замын байгууллагын салбар, нэгжийн дарга нь төр, засгийн шагналд ажилтныг тодорхойлох, төмөр замын байгууллагын даргын баталсан журамд заасан хэмжээнээс хэтэрсэн шагнал урамшууллыг үзүүлэх, доод байгууллага нь дээд байгууллага, удирдах ажилтныг шагнаж урамшуулахыг хориглоно.

Дөрөв. Сахилга, хариуцлага

- 4.1. Энэхүү журмын 2 дугаар хэсэгт заасан үүргийг биелүүлээгүй, сахилгын зөрчил гаргасан төмөр замын ажилтныг түүний гэм буруугийн байдлыг харгалзан Төмөр замын тээврийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн хариуцлага тооцно. Үүнд:
 - 4.1.1. сануулах;
 - 4.1.2. үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

- 4.1.3. төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх;
 - 4.1.4. ажлаас халах.
- 4.2. Дараах сахилгын зөрчил гаргасан төмөр замын ажилтныг төмөр замын хөдөлгөөний бус ажилд 1 жил хүртэл хугацаагаар шилжүүлэх сахилгын шийтгэл оногдуулж болно.
 - 4.2.1. Хөдлөх бүрэлдэхүүн жолоодохдоо зөрчил гаргаж осол, онцгой тооцоот гологдол гаргасан;
 - 4.2.2. Галт тэрэг хүлээн авах, явуулах, сэлгээний ажил хийх, хөдлөх бүрэлдэхүүнийг бэлдэхдээ зөрчил гаргаж осол гаргасан;
 - 4.2.3. Зам засвар хийгдэж буй газарт зохих ёсоор хамгаалалт хийгээгүйгээс хүний амь эрстсэн, гэмтсэн, осол гарсан;
 - 4.2.4. Хариуцсан үүргээ биелүүлээгүйгээс хөдлөх бүрэлдэхүүнийг бусад тээврийн хэрэгсэлтэй мөргөлдүүлсэн;
 - 4.2.5. Дохиолол, төвлөрүүлэлт, хориглол ба холбооны тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний технологийг зөрчиж осол гаргасан;
 - 4.2.6. Вагон чингэлгийн ачааг бэхлэх, байршуулах техникийн нөхцөл зөрчиж осол гаргасан;
 - 4.2.7. Шуудан, тээш, зорчигчийн вагоны үйлчлэгч нь хаалгаа түгжээгүй, буксын халалтад хяналт тавих төхөөрөмжийн ажиллагааг тогтмол шалгаагүйгээс болж хүний амь эрстсэн, гэмтсэн, осол гарсан;
 - 4.2.8. Галын аюулгүй байдлын дүрэм зөрчиж хөдлөх бүрэлдэхүүнд гал гаргасан;
 - 4.2.9. Аюултай бүсийн дэглэмийг хэрэгжүүлээгүйгээс хүний амь эрстсэн, гэмтсэн.
 - 4.3. Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэл болон дараах сахилгын зөрчил гаргасан төмөр замын ажилтныг ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулж, хөдөлмөрийн гэрээг ажил олгогчийн санаачилгаар цуцалж болно.
 - 4.3.1. Төмөр замын тээврийн сүйрэл гаргасан, нөхцөл бүрдүүлсэн болон хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан;
 - 4.3.2. Ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэсэн, ажилдаа согтуу буюу мансууран ирсэн;
 - 4.3.3. Төмөр замын объект, сэлбэг, хэрэгсэл, эд анги, бусад материалыг хулгайлсан, тоносон, үрэгдүүлсэн нь тогтоогдсон;
 - 4.3.4. Хөдлөх бүрэлдэхүүний эд ангийг санаатайгаар задалсан, сулласан болон эвдэж эд юмс нуусан;
 - 4.3.5. Албан тушаалаа ашиглан ачаа, тээш, ачаан тээш, зорчигчийг үнэ, хөлсгүй тээвэрлэсэн;
 - 4.3.6. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр дараалсан ажлын 3 өдөр ажил тасалсан, нийлбэр дүнгээрээ 4 ба түүнээс дээш өдөр ажил тасалсан;
 - 4.3.7. Улсын хилээр хууль бусаар эд зүйлийг нэвтрүүлэх зорилгоор төмөр замын тээврийн хөдлөх бүрэлдэхүүнийг нуувч болгон ашигласан;
 - 4.4. Ажил олгогч нь сахилгын шийтгэлийг ногдуулахаасаа өмнө тухайн ажилтнаас бичгээр тайлбар, тодорхойлолт, хүсэлтийг хүлээн авч зөрчлийн шалтгааныг олон талаас судалж, үнэн зөвийг бодитоор дүгнэнэ.
 - 4.5. Ажилтанд энэхүү журмын 5.1.3 дахь хэсэгт заасан сахилгын хариуцлага ногдуулсан тохиолдолд ажилтантай зөвшилцөж хөдөлгөөний бус ажилд томилно. Хэрэв ажилтан тус албан тушаалд очихоос татгалзвал хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож болно.

- 4.6. Энэхүү журмын 5.1.3 дахь хэсэгт заасан сахилгын шийтгэл хүлээсэн ажилтныг шийтгэлийн хугацаа дууссаны дараа Төмөр замын техник ашиглалтын дүрэм, Дохиоллын журам, Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам болон бусад холбогдох дүрэм журмын мэдлэгээр шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд хөдөлгөөнтэй холбоотой ажилд томилж болно.
- 4.7. Сахилгын шийтгэлийн талаарх гомдлоо ажилтан хууль тогтоомжид заасны дагуу шүүхэд гаргаж болно.
- 4.8. Сахилгын шийтгэлийн талаар гомдол гаргасан нь шийтгэлийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

Тав. Ажлын цагийн хуваарь

- 5.1. Хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээнд заасан долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэх цаг, нормчлогдоогүй ажлын өдөр, ээлжийн ажлын хоногт үргэлжлэх хугацаа, ээлжийн ажлын эхлэх, дуусах цаг, завсарлага, амралтын өдөр нь Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцсэн байна.
- 5.2. Барилгын салбар, байгууллагын харуул хамгаалалт, худалдаа, эмнэлгийн үйлчилгээ, боловсролын үйл ажиллагаа, нийтийн хоол /вагон ресторан/, авто тээврийн хэрэгслийн жолооч, харилцаа холбоо, вахтын аргаар ажил зохион байгуулдаг ажилтны ажил, амралтын хуваарийг энэхүү журмаар зохицуулахгүй.
- 5.3. Тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтныг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт зохицуулан ажиллуулах ба ажлын цаг нь тухайн сард ажиллавал зохих ажлын цагийн сангаас ихгүй байна.
- 5.4. Ээлжийн хуваариар ажилладаг ажилтны жинхэнэ ажилласан цаг нь ажлын ачаалал, зурмагийн зохицуулалтаас хамааран тухайн сарын нормт ажлын цагийн санд хүрэхгүй тохиолдолд нэмэлт ажил, үүргийг гүйцэтгүүлж болох ба ажлын цагийг нь нэгтгэн бодно.
- 5.5. Ажлын онцлогийг харгалзан тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ажилладаг ажилтныг шөнийн ээлжид 2-оос илүү удаа дараалан ажиллуулахыг хориглоно.
- 5.6. Ажилтныг хоёр ээлжид дараалан ажиллуулахыг хориглоно.
- 5.7. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтны ажлын өдрийн үргэлжлэх хугацааг хөдөлмөрийн стандартыг баримтлан тогтооно.
- 5.8. Эмэгтэй төмөр замын ажилтан, гадаадын иргэний хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

Зүтгүүрийн бригадын ажлын цагийн дэглэм

- 5.9. Зүтгүүрийн бригадын ажлыг тодорхой ээлжийн хуваариар зохион байгуулна. Зүтгүүрийн бригадын ээлжийн хуваарь зөрчигдсөн тохиолдолд ажилд дуудлагаар томилж болно. Дуудлагаар ажилд томилох аргыг хөдөлмөрийн дотоод дүрэмд тодорхой заасан байна.
- 5.10. Зорчигчийн, ачааны зүтгүүрийн бригадын ажилтны ажлын цагт дараах цаг хамаарна. Үүнд:
 - ажилд бэлтгэх цаг, зааварчлаг авах цаг, аяллын өмнөх болон дараах эмнэлгийн үзлэгт хамрагдах цаг;
 - аяллын цаг;
 - зүтгүүр хүлээлцсэн цаг;

- зорчигчоор аялсан хугацаа болон зорчигч хүлээсэн хугацаа;
 - ажил хүлээсэн цаг;
 - архины сорил тавьсан хугацаа зэргийг ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогч нормоор тогтоож өгнө.
- 5.11. Зүтгүүрийн бригадын ажлын цагийн дээд хязгаарыг ажилтны байгууллагын төлөөллөөс санал авч ажил олгогч тогтоох бөгөөд тогтоосон цагаас илүү ажиллуулахыг хориглоно.
 - 5.12. Зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах хугацаа нь 8 цагаас багагүй 12 цагаас ихгүй байна
 - 5.13. Ачаа, зорчигчийн машинчийн тасралтгүй ажлын цаг нь туслах машинчгүй үед 7 цагаас ихгүй байна.
 - 5.14. Хоёр өдөр дараалан шөнийн цагаар туслах машинчгүй ажиллахыг хориглоно.
 - 5.15. Галт тэрэгний зүтгүүрийн бригадын тасралтгүй ажиллах ажлын цаг нь 12 цагаас ихгүй байх бөгөөд харин эргэлтийн байранд шөнө амарсны дараа 10 цагаас ихгүй байна.
 - 5.16. Зорчигчийн галт тэрэгний зүтгүүрийн бригад шөнийн цагаар хоёроос их өдөр дараалан ажиллахыг хориглоно. Энэ шаардлага нь эргэлтийн депогоос буцаж байгаа зүтгүүрийн бригадад, зорчигч хэлбэрээр аялж байгаа зүтгүүрийн бригадад үйлчлэхгүй.
 - 5.17. Ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтан, түүний дотор сэлгээний бригадын ажилтны ажил хүлээлцэх цаг 20 минутаас ихгүй байна.
 - 5.18. Сэлгээний бригадын ажилтныг ээлж солилцохоос 30 минутын өмнө өөр өртөөнд ажиллуулахаар явуулахыг хориглоно.
 - 5.19. Зүтгүүрийн машинч, туслах машинчийн ажлын цагийг үндсэн байрнаас эргэлтийн байр хүртэл явсан, эргэлтийн байрнаас үндсэн байранд хүрэлцэн ирсэн цагийн нийлбэрээс амрах нөхцөлөөр хангагдсан өртөөнд амарсан хугацаа, зорчигчийн вагонд амарч явсан хугацааг хасаж, үндсэн ба эргэлтийн өртөөнд ажилласан бэлтгэл, төгсгөлийн цагийг ажилтан тус бүр дээр нэмж тооцно.
 - 5.20. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн дагуу дуудагдан ирсэн зүтгүүрийн бригадын ажилтныг аялал хойшлогдсон тохиолдолд 3 цагаас багагүй хугацаагаар амраагаад дахин дуудаж болно.
 - 5.21. Зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтан нь зүтгүүр, галт тэргийг хүлээн авахаар зүтгүүрээр явсан хугацааг ажлын цагт тооцно.
 - 5.22. Зүтгүүрийн болон галт тэрэгний бригад, мөн тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтны шөнийн цагаар ажиллах цагийг хорогдуулахгүйгээр тогтооно. Зааварлагч машинчийн аялалд явж ажилласан цагийг дагалдан явсан тухайн галт тэрэгний машинчийн ажлын цагийн нэгэн адилаар тооцно.
 - 5.23. Зорчигчийн галт тэрэгний тасалбарын явуулын нярав, тээш түгээгч тэдгээртэй адилтгах ажилтны ажлын цагийн хуваарийг зүтгүүрийн бригадын ажил, амралтын цагийн дэглэм адилаар тогтоож болно.

Тусгай, техникийн-алба, албаны үйлчилгээний вагонуудын үйлчлэгч ажилтнууд ба нормчлогдоогүй ажлын өдөртэй ажилтнуудын ажлын цагийн дэглэм

- 5.24. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам ба хамтын гэрээний дагуу тодорхой батлагдсан албан тушаалын жагсаалтаар төмөр замын тээврийн ажилтнуудыг зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн, ажиллагсад галт

тэргэнд дэх ээлжийн жижүүрийн цагийг оруулан нормчлогдоогүй ажлын өдрөөр тооцож болно.

- 5.25. Тусгай, техникийн-алба, албаны үйлчилгээний вагонуудын мэргэжилтэн, ажилтнуудын хувьд зайлшгүй ажлын өдрүүдийн үед тооцоолсон ажлын цагийн нийлбэрээр тооцох ба хэсэгт хуваана. Ажилтнуудын галт тэргэнд дэх ажлын ба амралтын хугацааг вагоны дарга эсвэл түүний орлогч зохицуулна.
- 5.26. Тусгай, техникийн-алба, албаны үйлчилгээний вагонуудын мэргэжилтэн, ажилтнуудын хувьд галт тэргэн дэх ажлын /ээлж/ үргэлжлэх хугацаа нь өдөрт 12 цагаас, вагоны бүртгэл, хяналт нь засвар үйлчилгээний газрын үед 7 хоногийн ажлын 5 өдөртэй тохиолдолд 8 цагаас тус тус хэтрэхгүй байх ёстой.

Төмөр замын тусгай хөдлөх бүрэлдэхүүн, зүтгүүр, зорчигчийн вагонуудад үйлчлэх ажилтны ажлын цагийн дэглэм

- 5.27. Байнгын ажлын түр байр /депогийн бүртгэл, хяналт, өртөө, замын ангийн хэсэг, зам засварын механикжсан анги, захиргаа/, хил, гаалийн болон бусад төмөр замуудын өртөөдөд зорчигчдод үйлчлэх төмөр замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний составын үйл ажиллагаа, түүнчлэн дээрх үйл ажиллагааг өгөх, гүйцэтгэх, буцах зэрэг ажлын цаг нь 24 цаг тутмын 7 цагаар /7 хоногийн 6 өдөртэй үед/ тооцно. Хил, гаалийн болон бусад төмөр замуудын өртөөдөд зорчигчдод үйлчлэх төмөр замын тусгай хөдлөх бүрэлдэхүүний бие бүрэлдэхүүний /состав/ үйл ажиллагаа нь 24 цагаас бага үед ажлын цагийг хувьчлан тооцно.
- 5.28. Төмөр замын тусгай өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн /төмөр замын тээврийн болон суурь бүтцийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий материалыг зайлшгүй зөөх тээвэрлэх төмөр замаар өөрөө явагч замаас авагддаг ба авагддаггүй хөдлөх бүрэлдэхүүн, мотовозы, дрезин, автомотрист/-ий ажилтан, ажилчдын ажлын цаг нь дараах байдлаар зохицуулна:
- Техникийн ба аяллын өмнөх зааварчлаг авах, эмнэлгийн урьдчилсан ерөнхий үзлэгт орох зэрэг ажилд бэлтгэх хугацаа;
 - машиныг ажилд бэлтгэх, үзлэг хийх хугацаа;
 - Хөдөлмөрийн үндсэн гүйцэтгэлийн шууд зарцуулалтын хугацаа;
 - Ажил гарахын өмнөх хүлээх хугацаа;
 - Замд аялах хугацаа;
 - Төмөр замын өртөөн дэх сэлгээний хугацаа;
 - Эцсийн зогсолтын байранд ирсэн хугацаа;
 - Ажилтан ажил олгогчтой зөвшилцсөний дагуу согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгуулах хугацаа.
- 5.29. Депогоос өртөө, өртөөнөөс депод, өргөх их засварт болон буцаахад хүйтнээр хүргэх үйлчлэгчийн ажлын цаг нь өдөрт 12 цагаар тооцно. Аяллын үед хөдлөх бүрэлдэхүүний нэгж /саланги зүтгүүр, бүлэг вагон/ бүрд 12 цагаас дээш цаг оногдвол 2 үйлчлэгчийг ажиллуулна.
- 5.30. Өртөө, депо, өргөх их засварт хөдлөх бүрэлдэхүүнийг хүлээлгэн өгөх, авах ажлыг 24 цаг тутмын 7 цагаар /7 хоногийн 6 өдөртэй үед/ тооцно.
- 5.31. Галт тэрэгний бүрэлдэхүүнд ажиллаж байгаа зүтгүүрийн засварт /2 зүтгүүрээр/ зүтгүүрийн бригадын гишүүн бүрийг машинчийн замналын хуудсанд тэмдэглэх ба өдөрт 12 цагаас хэтрэхгүйгээр тооцно.
- 5.32. Тусгай үйлчилгээний болон албан хэрэгцээний вагоны үйлчлэгчийн ажлын цагийн хуваарийг батлагдсан ажил, амралтын нормативт цагийг үндэслэн нэг ээлжид 12 цагаас ихгүй байхаар зохицуулах бөгөөд аялалд явах цагийг

галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагаар тогтооно.

- 5.33. Зорчигчийн галт тэрэгний вагоны үйлчлэгчийн ажлын цагийг үндсэн байрнаас эргэлтийн байр хүртэл явсан, эргэлтийн байрнаас үндсэн байранд хүрэлцэн ирсэн цагийн нийлбэрийг үйлчлэгчийн тоонд хувааж, үндсэн ба эргэлтийн өртөөнд ажилласан бэлтгэл, төгсгөлийн цагийг үйлчлэгч тус бүр дээр нэмж тооцно. Вагоны үйлчлэгчийн ажлын цагт вагоныг харж хамгаалах, зорчигчид байрласан үед жижүүрлэх, өвлийн улиралд галлагаа хийх цагийг оруулан тооцно.
- 5.34. Зорчигчийн галт тэрэгний бригадын механик, засварчин болон тэдгээртэй адилтгах ажилтны ажлын цагийн хуваарийг хөдлөх бүрэлдэхүүнд үйлчлэх ажилтны ажил, амралтын цагийн дэглэм адилаар тогтоож болно.

Зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн, хөргөлтийн хэсэг /секц/, ажлын өрөөний зориулалт бүхий, бие даасан хөргөлттэй вагонуудад ажиллагсдын ажлын цагийн дэглэм

- 5.35. Зорчигчийн галт тэрэгний аюулгүй байдлыг хангахад зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн, ажиллагсад галт тэргэнд дэх ээлжийн жижүүрийн цагийг оруулан тооцсон ажлын цагийн дэглэм нь орон нутгийн онцлогт тохируулан тухайн байгууллагын удирдлагын тооцоолон гаргасан шийдвэрийн дагуу галт тэрэг тус бүрд ажлын даалгаврыг ээлжийн хуваарийн дагуу зохицуулна.
- 5.36. Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн, ажиллагсдын галт тэргэн дэх ажлын цаг /ээлж/-ийн тасралтгүй үргэлжлэх хугацаа нь 12 цагаас, өдөр бүрийн ажлын цаг /ээлж/-ийн нийт үргэлжлэх хугацаа нь 16 цагаас хэтрэхгүй байх ёстой.
- 5.37. Зорчигчийн галт тэрэгний тээврийн аюулгүй байдлыг хангахад зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн, ажиллагсад галт тэргэнд дэх ээлжийн жижүүрийн цагийг оруулаагүй тооцсон ажлын цагийн дэглэм нь орон нутгийн онцлогт тохируулан тухайн байгууллагын удирдлагын тооцоолон гаргасан шийдвэрийн дагуу галт тэрэг тус бүрд ажлын даалгаврыг нэг аяллын үед жижүүрлэн ажиллах хуваарийн дагуу зохицуулна.
- 5.38. Зорчигчийн вагоны үйлчилгээнд тухайн аяллын вагоны хоёр үйлчлэгч ажиллах тохиолдолд аяллын мөрөн дэх нийт ажиллах хугацааг тус бүрд таллан оногдох ба зорчигчийн галт тэрэгний эргэлт, дамжин өнгөрөх цэгүүдэд ажиллах ээлжийн хуваарьтай байна.
- 5.39. Хөргөлтийн хэсэг /секц/, ажлын өрөөний зориулалт бүхий, бие даасан хөргөлттэй вагонуудын галт тэрэгний бүрэлдэхүүний ажлын цагийн үргэлжлэх хугацаа нь холбогдох дүрмийн дагуу 45 өдрөөс хэтрэхгүй байх ёстой. Хэрэв галт тэрэг ачаатай болон депо засварт орохоор болсон бол тухайн галт тэрэгний үргэлжлэх хугацаан дээр 15 хоногоор нэмэгдүүлж болох ба галт тэрэгний бүрэлдэхүүн зөвшөөрсөн бол түүнээс илүү хугацаатай байж болно.
- 5.40. Аяллын үед Монгол Улсын нутаг дэвсгэрээр өнгөрч буй гадаад улсын бүх зорчигчийн галт тэрэг болон хөргөлтийн хэсэг /секц/, ажлын өрөөний зориулалт бүхий, бие даасан хөргөлттэй вагонуудыг бусад төмөр замуудад хүлээлцэх, буцаан авах, бүх төрлийн галт тэрэг, вагонуудыг хил гаалийн үзлэгт хамруулах үед ажиллаж байгаа галт тэрэгний бүрэлдэхүүний ажлын цаг нь 24 цаг тутмыг 8 цагаар аяллын үеийн, хил гаалийн, төмөр замуудын вагон хүлээлцсэн байдлаар байнгын тогтмол ажлын цагаар тооцож болно.

- 5.41. Хэрэв аяллын үед хил гаалийн болон бусад өртөө зөрлөгт 24 цагаас бага байвал ажлын цагийг хувьчлан тооцож олгоно.
- 5.42. Хөргөлтийн хэсэг /секц/, ажлын өрөөний зориулалт бүхий, бие даасан хөргөлттэй вагонуудад, түүнчлэн нөөцөд байгаа болон бусад ажилтан бүрийн /механик, тээшийн болон тусгай вагоны үйлчлэгч/ нарын ажлын үргэлжлэл нь хөргөлттэй вагоны ачааны тоо хэмжээнээс үл хамаарч өдөрт 12 цагаас хэтрэхгүй байх ёстой.
- 5.43. Хөргөлтийн хэсэг /секц/, ажлын өрөөний зориулалт бүхий, бие даасан хөргөлттэй вагонууд дунд /депо/ болон өргөх их засварт орох, хүлээх, өгөх, хүлээн авч аялалд бэлтгэх зэрэг нийт зарцуулсан хугацааг ажилласан цагт оруулж тооцно.
- 5.44. Хөргөлтийн хэсэг /секц/, ажлын өрөөний зориулалт бүхий, бие даасан хөргөлттэй вагонууд дунд /депо/ болон өргөх их засварт орох, хүлээх, өгөх, хүлээн авч аялалд бэлтгэх зэрэг ажлын цагийг ажил олгогчийн баталсан дотоод журмын дагуу тооцно.

Сэргээн босгох галт тэрэгний ажлын цагийн дэглэм

- 5.45. Сэргээн босгох галт тэрэгний ажилтны ажлын цагийг тооцоход нэгтгэх аргыг хэрэглэнэ.
- 5.46. Сэргээн босгох галт тэргийг төмөр замын сүйрэл, осол, гологдол, үйлдвэрлэлийн осол, Байгалын гамшгийг арилгах зорилгоор аялалд гаргана. Шаардлагатай бол бусад салбар, нэгжээс ажилчдыг татан ажиллуулж болно. Сэргээн босгох галт тэрэгний бригад болон бусад салбар, нэгжээс татагдан ирсэн ажилчдын ажлын цагт уг галт тэргийг байрлуулсан үндсэн газарт ирсэн цагаас сэргээн босгох ажилд оролцоод буцаж ирсэн цаг хүртэлх бүх цагийг тооцно.
- 5.47. Сэргээн босгох галт тэрэгний бригад, бусад салбар, нэгжээс татагдан ирсэн ажилчид нь төмөр замын сүйрэл, осол, гологдол, үйлдвэрийн осол болон байгалийн гамшгийг удаан хугацаанд сэргээн засварлах бол бүх ажилтанд амралтын завсарлага өгч, хоол хүнсээр үйлчилнэ. Энэхүү завсарлага нь ажлын цагт орохгүй.
- 5.48. Сэргээн босгох галт тэрэгний бригад нь сургалт-бэлтгэлийн ажил гүйцэтгэх, мөн гэрээгээр ажил гүйцэтгэхээр бол ээлжийн хуваарийн үндсэн дээр ажлын цагийг тодорхойлно.

Замын аж ахуйн ажилтны ажлын цагийн дэглэм

- 5.49. Зам, засварын машинт станцын ажилчид ажил гүйцэтгэж буй хэсэглэл рүү зорчихдоо тусгай ажилчдын тусгай галт тэргээр зорчиж зурмагийн дагуу замаар зорчсон цагийг оруулж тооцно. Хэрвээ ажлын байрны үйлдвэрлэлийн хэсэг нь үйлчилгээний хэсгээс гадуур байрладаг бол ажлын 5 өдрөөр ажиллах 24 цагийн 8 цагт, 6 өдрөөр ажиллах 24 цагийн 7 цагт зорчсон хугацааг оруулна.
- 5.50. Төмөр замын барилгын болон замын машин механизмын техникийн үйлчилгээ хийх ажилтан, мөн мэргэжилтний ажлын цагт дараах цагууд орно. Үүнд:
- Зааварчлаг авах, аяллын өмнөх, эрүүл мэндийн үзлэгийн цаг мөн журамд зааснаар машинч, туслах машинчийн аяллын өмнөх, эрүүл мэндийн үзлэгийн цаг;
 - Машин механизмыг ажилд бэлтгэх цаг;
 - Машин механизм дээр ажиллаж байх үеийн цаг;

- Зүтгүүрт залгах, түүнээс салгах үеийн хүлээх цаг;
- Хоорондын замд явуулахыг хүлээх цаг;
- Хоорондын замаар өнгөрөх үеийн цаг;
- Төмөр замын өртөөнд сэлгээ хийх цаг;
- Машин механизмыг зогсоолд байрлуулах цаг;
- Холбогдох журам болон хөдөлмөрийн гэрээний дагуу архины сорил шалгуулах буюу алкотестерээр шалгуулах цаг;
- Хоппер-дозатор болон думпкар вагонуудын ачилт, буулгалтад бэлтгэх, тэдгээрийг тээвэрлэлтийн бэлэн байдалд байршуулах цаг.

5.51. Замын барилга угсралтын машин механизмыг галт тэрэгний бүрэлдэхүүнд холбох, ажлын бус горимд бие дааж өөр өртөөнд шилжих мөн өөрөө буулгагч хоппер-дозатор, думпкар вагоноор бусад өртөөнд ачаа ачиж, буулгах, буцах зэрэг үйл ажиллагаанд оролцох тохиолдолд ажил олгогч, ажилчдын төлөөлөл нар тохиролцож барилга угсралтын машин механизмын ээлжийн ажилтны ажил, амралтын хуваарийг зохионо.

Ажил эхлэх ба дуусах цаг

- 5.52. Байнгын ажлын байранд хүрэлцэн ирэх цагийг /ажил эхлэх/, ажилтан хөдөлмөрийн үүргээ гүйцэтгэж тарах цагийг /ажил дуусах/ төмөр замын байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно.
- 5.53. Зүтгүүр, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүний жолооч эсвэл машинч түүний туслах болон галт тэрэг, хөргөлттэй вагон, секц, замын барилгын машин механизм, тусгай ачааны вагоны бригадын /ээлжийн, аяллын ажилтны байнгын ажлын байр/-ны ажил эхлэх цагийг ажлын хуваарь, наряд эсвэл дуудлагаар зохицуулах ба байгууллагын дотоод журам эсвэл хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.
- 5.54. Зүтгүүр, өөрөө явагч хөдлөх бүрэлдэхүүн, галт тэрэг, бүрэлдэхүүн, замын барилгын машин, хөргүүртэй вагон, секц болон вагоныг хүлээлгэж өгч, холбогдох техникийн баримт бичигт бүртгэл хийсний дараа ажлын цаг дуусна.
- 5.55. Аялал цуцлагдсан, байгууллага эсвэл салбар нэгжийн удирдлагын шийдвэр, дотоод журмаар ээлжийг шинэчлэн тогтоосон бол ажлын цаг дуусна.
- 5.56. Ээлжийн ажилтан, ажлын өдрийг хэсэглэн хуваах зарчмаар ажилладаг ажилтнуудын ажлын эхлэх, дуусах цагийг ээлжийн ажлын хуваариар тогтооно.
- 5.57. Ажлын өдрийг хэсэглэн хуваах зарчмаар ажилладаг ажилтны ажлын өдрийн эхлэл, төгсгөлийг галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагтай уялдуулан тогтооно.
- 5.58. Зүтгүүр, галт тэрэг, вагоныг хүлээн авах, хүлээлгэн өгөх цагийн нормативыг төмөр замын байгууллагын дарга тогтооно.
- 5.59. Зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтны зорчигчийн галт тэргэнд зорчигчоор явсан цагийг ажилласан цагт тооцохгүй.
- 5.60. Төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр зүтгүүр болон галт тэрэгний бригадын ажилтан депод хүрэлцэн ирж, зүтгүүр, галт тэргийг хүлээн авахаар хүлээсэн хугацааг сул зогсолт гэж тооцно.
- 5.61. Хил гарах, дамжуулах галт тэрэг, сэлгээний ажил, түлхэгч зүтгүүр дээр тогтмол буюу түр хугацаагаар ажиллуулахаар зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтныг байнгын оршин суудаг газраас явуулахад энэ журмын 3.11 дэх заалт хамаарахгүй.**

- 5.62. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу дуудагдан ирсэн зүтгүүрийн бригадын ажилтан үндсэн депогийн амралтын байранд амарсан тохиолдолд ажилласан болон сул зогсолт гэж тооцохгүй.

Илүү цаг

- 5.63. Хамтын болон хөдөлмөрийн гэрээнд тохиролцсоны дагуу төмөр замын тээврийн хэвийн тасралтгүй үйл ажиллагаанд саад учруулсан байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах эсвэл яаралтай хийхгүй бол хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгуулахаар галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг илүү цагаар ажиллуулж болно.
- 5.64. Ажилтныг хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ердийн ажлын өдрийн үргэлжлэх хугацаанаас 4 цагаас илүүгээр ажиллуулж болохгүй.
- 5.65. Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулна. Хэрэв амруулаагүй бол Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлсийг олгоно.
- 5.66. Ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн дагуу нийтээр амрах баярын өдөр, долоо хоногийн бүрийн амралтын өдөр ажиллах нь илүү цагт хамаарахгүй. Ингэхдээ хөдөлмөрийн гэрээнд тусгаж 2 тал тохиролцсон байна.
- 5.67. Ээлжийн хуваариар ажилладаг төмөр замын ажилтны ажлын цаг нь тухайн сарын нормт цагаас хэтрэх ёсгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд нөхөн амруулах эсвэл нэмэгдэл хөлсийг олгоно.

Ажлын цагийг сунгах

- 5.68. Зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтан, мөн ээлжийн хуваариар ажлын цаг нь зохицуулагддаг ажилтныг байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгахаас бусад тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөний зурмагаар тогтоосон хугацаанаас илүү цагаар сунгаж ажиллуулахыг хориглоно.
- 5.69. Зүтгүүр, галт тэрэгний бригадын тасралтгүй ажиллагааны үргэлжлэх хугацааг сунгах зайлшгүй тохиолдолд төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр зохицуулна. Энэ тохиолдолд захиргаа уг ажилтныг өөр ажилтнаар түргэн хугацаанд солих арга хэмжээг яаралтай авах үүрэгтэй.
- 5.70. Төмөр замын тээврийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагаанд саад учруулсан байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, эсвэл яаралтай хийхгүй бол хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэхээр галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг амралт эдэлж буйг үл харгалзан төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр ажилд дуудан оруулж болно.
- 5.71. Зүтгүүр, дохиолол холбоо, эрчим хүч, ус хангамжийн байгууламж эвдэрсэн, зам гэмтсэн, тусгай үйлчилгээний галт тэрэг явуулах, өнгөрүүлэх тохиолдолд галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг амралтаас ажилд дуудан оруулж болно.
- 5.72. Дээр дурдсанаас бусад тохиолдолд галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтныг бүрэн амарч дуусаагүй байхад нь ажилд дуудахыг хориглоно.

Амралт

- 5.73. Төмөр замын тээврийн ачаа их хэмжээгээр хуримтлагдсанаас хөдлөх бүрэлдэхүүн, вагоны сул зогсолт нэмэгдэх, тээврийн хэвийн ажиллагаа алдагдахаас сэргийлэх зорилгоор хойшлуулшгүй засвар, ачих буулгах ажилд нийтээр амрах баярын өдөр болон долоон долоо хоногийн амралтын өдөр ажилтныг ажиллуулж болно.
- 5.74. Зүтгүүрийн бригадын ажилтны долоо хоногийн амралтын хугацааг зурмагт 48 цагаас багагүй, 72 цагаас ихгүй байхаар тухайн сарын ажлын ээлжийн хуваарьт тэнцүү хуваарилж тусгана. Энэ амралтыг ажилтны байнгын оршин суух газарт нь олгох ба амрах хуваарийг урьдчилан мэдэгдсэн байна.
- 5.75. Тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ажилладаг ажилтан /галт тэрэгний ээлжийн зохицуулагч, өртөө, зөрлөгийн жижүүр, туслах жижүүр, холбогч, найруулагч, найруулагчийн туслах, сумчин, ачаа вагон хүлээлцэгч, вагон бичээч, вагон үзэгч, гармын жижүүр зэрэг/-ы долоо хоногийн амралтын хугацаа нь тухайн сарын амралтын цагаас багагүй байна.
- 5.76. Байгалийн гамшиг, сүйрэл, осол гарсан тохиолдолд төмөр замын байгууллагын даргын шийдвэрээр долоо хоногийн амралтыг бууруулан 24 цагаар тогтоож болох ба дутууг дараа нөхөн амраана.
- 5.77. Галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажлын байранд ажилтны амрах, хооллох завсарлагын хугацааг 30 минутаас багагүй, 2 цагаас ихгүй байхаар хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно. Харин байгаль, цаг уурын онцгой нөхцөл /хэт халалт, хүйтрэлт/-д ажлын өдрийн тусгай завсарлагын хугацааг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган 2-оос дээш цагаар зохицуулж болно.
- 5.78. Байгаль, цаг уурын онцгой нөхцөл /хэт халалт, хүйтрэлт, цасан болон шороон шуурга зэрэг/ бий болсон тохиолдолд замчид, ил задгай газар ажиллагсдын ажлын өдөрт тусгай завсарлагыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд зааснаар зохион байгуулж болно.
- 5.79. Ажлын өдрийн дараах хэвийн амралтын үргэлжлэх хугацааг 8 цагийн ажлын өдөртэй ажилтанд 16, 7 цагийн ажлын өдөртэй ажилтанд 17, 12 цагийн ээлжийн хуваариар ажилладаг ажилтанд 24 цагаар тус тус тогтооно.
- 5.80. Зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтны байнгын оршин суудаг газарт олгох амралтыг тооцохдоо хоёр талын аялалд зарцуулсан нийт цагийг хэвийн амралт зохицуулах итгэлцүүрээр үржүүлж, гарсан үржвэрээс эргэлтийн байр буюу амрах нөхцөлөөр хангагдсан зорчигчийн вагонд амарсан хугацааг хасаж тооцно. Итгэлцүүр 2,0-ыг долоо хоногийн ажлын өдрийн дараах амралтын цагийн нийлбэрийг долоо хоногийн ажлын нормт цагт хувааж гаргана ($80:40 = 2.0$).
- 5.81. Ажилтны байнгын оршин суудаг газар дахь амралтыг ажлын шаардлагаар 12 цаг хүртэл хугацаагаар багасгаж болох ба тасралтгүй амарсан хугацаа нь 24 цагаас багагүй байна.
- 5.82. Эргэлтийн болон солилцох байранд зүтгүүрийн бригадын аялал нэг талдаа 4 цагаас илүү үргэлжлэх тохиолдолд гүйцэтгэсэн ажлын цагийн хагасаас буюу 3 цагаас багагүй хугацаагаар амарсан байна.
- 5.83. Зүтгүүрийн болон галт тэрэгний бригадын ажилтныг эргэлтийн байр буюу ажил дууссан газарт нь зохих амралтыг нь эдлүүлэхгүйгээр буцааж болох боловч буцах замд нь ажиллуулж болохгүй.
- 5.84. Зорчигчийн галт тэрэгний бригадын ажилтны ажлын цагийг халаа /турный/ ээлжээр зохион байгуулах тохиолдолд ажилтны байнгын оршин суудаг газарт олгох амралтыг хоёр талын аялал хийсний дараа тооцож олгоно.

- 5.85. Амралтын үргэлжлэх хугацааг тодорхойлохдоо нийт ажилласан хугацааг 2-оор үржүүлж, замд амарсан хугацааг хасаж тодорхойлно.
- 5.86. Ажлын цагийн хуваарийг зохиоходоо галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн болон суурь бүтэц дэх зурмагтай зохицуулж, дараах зүйлүүдийг удирдлага болгоно:
- Тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажилладаг ажилтан, мөн түүнчлэн ажлын цагийг хэсэглэн хуваах зохицуулалтаар ажилладаг ажилтны ажлын зурмагийг төмөр замын байгууллагын дарга батална.
 - Ажлын цагийг хэсэглэн хуваах зохицуулалтаар ажилладаг ажилтны ажлын зурмагийг үдийн хоолны завсарлагыг оролцуулан 2-оос илүүгүй завсарлагатай, завсарлага бүрийн үргэлжлэх хугацааг 1 цагаас багагүй, хоногийн туршид амралтын тасралтгүй үргэлжлэх хугацаа 12 цагаас багагүй байхаар тус тус зохионо.
 - Төмөр замын байгууллага, салбар нэгжийн захиргаа нь ажилтны ажил, амралтын ээлжийн хуваарийг сар эхлэхээс 3 хоногийн өмнө ажилтанд танилцуулж, ажлын байранд ил тавьсан байна.
- 5.87. Зүтгүүр, галт тэрэгний бригадын болон тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжийн хуваариар ажилладаг ажилтны ажлын цагийн хуваарийг төмөр замын байгууллагын захиргаанаас галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн болон суурь бүтэц дэх зурмаг, долоо хоногийн амралт, сарын нормт ажлын цагийн тасралтгүй үргэлжлэх хугацаа зэргийг харгалзан зохионо.
- 5.88. Ажлын цагийн хуваарьт ажилтны ажил, амралтын цаг тодорхой заагдсан байх ба амарч байгаа ажилтныг зурмагтай танилцуулах, шийдвэр өгөх зэргээр захиргаанаас үүрэг хүлээлгэхийг хориглоно. Байгалийн гамшиг, сүйрэл, осол гарсан тохиолдолд энэ заалт хамаарахгүй бөгөөд бригад дуудах дэгийг төмөр замын байгууллагын хөдөлмөрийн дотоод журмаар тодорхойлно.
- 5.89. Ажлын цаг нь ээлжийн хуваариар болон хэсэглэн хуваах журмаар зохицуулагддаг ажилтны ажлын цагийг сар, улирлын эцэст нэгтгэн тооцно.
- 5.90. Сарын нормт ажлын цагийн санг тодорхойлохдоо ажлын өдрийн хэвийн үргэлжлэх хугацаа /8 цаг/-г тухайн сарын ажлын өдрийн тоогоор үржүүлж гаргана.

Зургаа. Хяналт

- 6.1. Энэхүү журмын биелэлтэд төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хяналт хариуцсан нэгж, төмөр замын байгууллага болон салбар, нэгжийн удирдлага, дотоод хяналтын нэгж хяналт тавина.

__оОо__